

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-6

1.Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төсөл 3-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Жаргалсайхан;
Чөлөөтэй: А.Ариунзаяа, Ж.Батсуурь.

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хуулийн төслийг Байнгын хорооны дарга Б.Баярбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулж, тайлбар хийв.

Б.Баярбаатар: Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуульа.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 0
Бүгд: 9
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 10 минут.

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ дахин өдрийн мэнд хүргэе. Үдээс өмнө хуралдаж бид нэг асуудлыг хэлэлцэж баталсан байгаа. Үдээс хойш яаралтай дахин хуралдах нөхцөл байдал үүсэж, Даргын дэргэдэх зөвлөлөөр өнөөдрийн 16 цагт хуралдуулах саналыг оруулж дэмжигдсэн учраас хурал зарлагдаж, 16 цагийн 2025 оны 1 сарын 8-ны өдрийн 16 цагийн хуралдааны ирцийг танилцуулъя. Баярмагнайн Баярбаатар ирсэн байна, Аюушийн Ариунзаяа чөлөөтэй, Хүрэлбаатарын Баасанжаргал ажлын хэсгийн хурал давхацсан байна, Жамбын Батсуурь орж ирээгүй байна, Даваасамбуугийн Ганмаа гишүүн орж ирээгүй байна, Болдын Жавхлан гишүүн ирсэн байна, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн орон нутагт томилолттой, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна, Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн учраас ирц 58,3 хувиар хүрсэн учраас хурлыг нээснийг мэдэгдье.

Нэг асуудлыг хэлэлцэнэ. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг манай Байнгын хороо өнөөдөр хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа орёе.

Танилцуулгыг би өөрөө уншиж танилцуулъя. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийн танилцуулга. Цөмийн энерги ашиглалттай холбоотой асуудлыг Монгол Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар боловсронгуй болгон баталж, хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Нөгөө талаар Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт энэ хуулийн 30.1-д заасан гэрээг хөрөнгө оруулагчтай Засгийн газар байгуулахдаа Улсын Их Хурлын Аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Байнгын хороотой зөвшилцөнө гэж заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн Бадрах Энержи ХХК-ийн Хөрөнгө оруулагч Орано Майнинг САС компанитай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр ирүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар бүлэгт олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тусгайлан зохицуулдаг боловч Цөмийн энергийн тухай хуульд заасан Хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх асуудлыг тухайлан

хуульчлаагүй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж, саналаа нэгдсэн чуулганы хуралдаанд оруулна гэж заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу Хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн Засгийн газраас Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д заасны дагуу хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөж дуустал хугацаанд дагаж мөрдөнө.

Хуулийн төслийг үргэлжлүүлээд уншиж танилцуулчихъя протоколд үлдэх учраас. Монгол Улсын хууль. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д заасны дагуу зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл, холбогдох баримт бичгийг /цаашид гэрээний төсөл гэх/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэхээс өмнө нийт гишүүдэд тараана.

2 дугаар зүйл. Гэрээний төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо тус тусдаа урьдчилан хэлэлцэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

3 дугаар зүйл. Нам, эвслийн бүлэг гэрээний төслийг хэлэлцэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлж болно.

4 дүгээр зүйл. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төсөл, холбогдох баримт бичиг, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.

5 дугаар зүйл. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд гэрээний төслийг Ерөнхий сайд эсхүл тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна.

6 дугаар зүйл. Гэрээний төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

7 дугаар зүйл. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийн талаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг нь гаргана.

7.1.Гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрч, тухайн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох.

7.2.Гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй хууль тогтоомжид нийцсэн тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэх.

7.3. Гэрээний төслийг дэмжээгүй бол шалтгааныг нь тайлбарласан санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэх.

8 дугаар зүйл. Гэрээний агуулга, ач холбогдлыг нь харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гишүүдийн олонхын саналаар гэрээг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болно.

9 дүгээр зүйл. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэсэн бол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

10 дугаар зүйл. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

11 дүгээр зүйл. Энэ хуулийн 9 болон 10 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлсэн гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг дэмжсэн бол хамт оруулсан Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.

12 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн Засгийн газраас Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д заасны дагуу хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөж дуустал хугацаанд дагаж мөрдөнө гэсэн ийм 12 зүйл бүхий Дэгийн хуулийн 1 удаагийн хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байна. Төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Рэгдэл гишүүнээр тасаллаа. Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Энэ 11 дүгээр зүйл дээр 9 болон 10 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлсэн гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх санал, дүгнэлтийг дэмжсэн бол Их Хурлын тогтоол баталсанд тооцно гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гэж бид юуг нь ойлгож авч үзэх вэ?

Б.Баярбаатар: Баасандорж дарга хариулах уу? Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж дарга микрофоныг өгье.

Б.Баасандорж: Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Рэгдэл гишүүний асуултад хариулъя. 11 дүгээр зүйлийг асууж байна. Энэ хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гэдэг маань яг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос оруулсан санал, дүгнэлтийг чуулганы тухайн өдрийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжих юм бол 64 биш. Хууль баталдаг олонх биш, ердийн олонх. Чуулганы хуралдаанд ирц бүрдээд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн бол тухайн нөгөө зөвшилцөхийг зөвшөөрсөн биш ээ, гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээг зөвшөөрсөн тухай тогтоол батлагдсанд тооцно гэсэн агуулга байгаа.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Яг энэ заалтыг дангаар нь уншаад үзэхээр хуралдаанд 65 гишүүн оролцоод 33-ын саналаар нь баталчих юм шиг уншигдаад байгаа юм. Энэ найруулгадаа байна уу, юундаа байна вэ? Тэгэх үү.

Б.Баярбаатар: Ердийн олонх чинь ерөөсөө л тэр байхгүй юу. Хуралдааны өглөөний ирцээр 100 гишүүн байна уу, 90 гишүүн байна уу тэрний олонх нь зөвшөөрсөн тохиолдолд 50 + 1-ээр буюу ердийн олонхоор тогтоол батлагдана гэсэн үг. Аюулгүй байдал, гадаад бодлогын.

Д.Рэгдэл: Нөгөө 64-өөр биш байх нь.

Б.Баярбаатар: 64-өөр биш. Тэр чинь нийт гишүүдийн олонх.

Д.Рэгдэл: Харин тийм тэгж ойлгогдоод байгаа юм.

Б.Баярбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Санал хэлэх гишүүн байхгүй байна. Саналыг тасаллаа. Санал хураалт явуулна.

Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. 9 гишүүн санал хураалтад оролцсоноос 9 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хурааж дууслаа. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай хийх гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Ёс зүй, дэгийн Байнгын хороо саналаа нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ. Хурал даргалагч би өөрөө саналаа танилцуулчихъя.

16.21 цаг

Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хурлыг хаалаа. Гишүүдийг хүрэлцэн ирсэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА